# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 10 өдөр Дугаар 89 Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 79 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам”-ын 2.2.2, 2.2.3, 2.2.4, 3.1.4, 3.2.3, 3.2.5, 4.1, 4.4, 4.5 дах заалт болон мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмийн гаж нөлөөг мэдээлэх хуудас”-ны Мэдээлэл илгээх хаягын …Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс... гэснийг ...Эрүүл мэндийн хөгжлийн төв... гэж өөрчлөх, гуравдугаар хавсралтаар батлагдсан “Эмийн гаж нөлөөний бүртгэл”-ийн загварт өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам батлах тухай” 415 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080300

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 10 өдрийн
89 дугаар тушаалын хавсралт

## А. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨНИЙ БҮРТГЭЛ

| № | Овог, нэр | Нас | Хүйс | Хэвтэн эмчлүүлсэн эмнэлэг, тасаг | Эм хэрэглэсэн заалт | Гаж нөлөө илэрсэн эм | | | | | Эм хэрэглэж эхэлсэн огноо | Гаж нөлөө илэрсэн огноо | Илэрсэн гаж нөлөөний хэлбэр | Гаж нөлөөний төгсгөл | ЭЭЗХорооны үнэлгээ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Олон улсын нэр | Худалдааны нэр | Тун, хэлбэр | Цувралын дугаар | Үйлдвэрлэгч улс | | | | | Илэрхий | Үнэмшилтэй | Байж болох | Эргэлзээтэй |
| | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | |

## Б. ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨНИЙ НЭГДСЭН БҮРТГЭЛ

| Гаж нөлөөний Хуудасны дугаар | Мэдээлэл ирүүлсэн байгууллагын нэр | Нас | Хүйс | Хэвтэн эмчлүүлсэн эмнэлэг, тасаг | Эм хэрэглэсэн заалт | Гаж нөлөө илэрсэн эм | | | | | Эм хэрэглэж эхэлсэн огноо | Гаж нөлөө илэрсэн огноо | Илэрсэн гаж нөлөөний хэлбэр | Гаж нөлөөний төгсгөл | Шалтгаан хамаарал | | | | Эм судлалын салбар зөвлөлийн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Олон улсын нэр | Худалдааны нэр | Тун, хэлбэр | Цувралын дугаар | Үйлдвэр-лэгч, улс | | | | | Илэрхий | Үнэмшилтэй | Байж болох | Эргэлзээтэй | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | |